# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 14 өдөр Дугаар А/120 Сүхбаатар сум

Дэмжих баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "л", 29.2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/251, А/380 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам"-ын 2 дахь хэсгийн 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, гэр бүл хүүхдийг аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор "Дэмжих баг"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Ахлагч: | -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга |
| Нарийн бичгийн дарга: | -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Гэр бүлийн асуудал харлуцсан мэргэжилтэн |
| Гишүүд: | -Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн |
| | -Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга |
| | -Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын халамжийн хэлтсийн дарга |

-Боловсрол, соёл, урлагийн газрын Насан туршийн боловсрол хариуцсан мэргэжилтэн, өмгөөлөгч

2. Дэмжих багийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангах арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг "Дэмжих баг"-ийн ахлагч /П.Оюун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ш.ОРГИЛ